



ДОРНОД АЙМГИЙН ОНЦГОЙ КОМИССЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2021 оны 08 дугаар сарын 25 өдөр

Дугаар 77

Хэрлэн сум

LXXVII ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

Аймгийн Онцгой комиссын 77 дугаар хуралдаан 2021 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн 08:00 цагт танхимаар 61,5 хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг аймгийн Засаг дарга, Онцгой комиссын дарга М.Бадамсүрэн даргалж холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

СОНССОН НЬ:

1.Коронавируст халдвар \Ковид-19\-ын одоогийн нөхцөл байдлын талаар мэдээлэл танилцуулах,

*Аймгийн ерөнхий тархвар судлаач*

2.Коронавируст халдвар \Ковид-19\-ын үед тусгаарлах, эмчлэх байраар төрийн байгууллагын барилгыг дайчлан ажиллах талаар хэлэлцэж шийдвэр гаргах,

*Эрүүл мэндийн газар*

3.Хот хоорондын зорчигч тээврийн үйлчилгээний талаар асуудал хэлэлцүүлэх,

*Автомтээврийн төв*

4.Чулуунхороот суманд малын халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэн талаар мэдээллийг танилцуулах,



*Мал эмнэлгийн газар*

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг.Бүсийн төв аймгийн Онцгой байдлын газрын дарга, Онцгой комиссын орлогч дарга, хурандаа Г.Нармандах,  
Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа нарт:

1.1.Политехникийн коллежийн дотуур байрыг 09 дүгээр сарын 10-ны өдрийг хүртэл үргэлжлүүлэн тусгаарлах, эмчлэх байраар дайчлан ажиллах тухай аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

1.2.Халдварын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан хувийн эрүүл мэндийн байгууллагуудыг дайчлан ажиллахад гарсан хөрөнгийг Эрүүл мэндийн даатгалын сангаас шийдвэрлэх тухай Аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

/  / М.Бадамсүрэн  
/  / х/ч Б.Цогтбаяр

1.3.Халдварын тархалт нэмэгдэж байгаатай холбогдуулан төрийн болон хувийн хэвшлийн байгууллагуудтай зөвшилцөж барилгыг тусгаарлах, эмчлэх байраар ашиглах талаар аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Хоёр.Авто тээврийн төвийн дарга, Онцгой комиссын гишүүн Ц.Мөнхтөр-д:

2.1.Хот хоорондын Чойбалсан-Улаанбаатар, Улаанбаатар-Чойбалсан чиглэлийн зорчигч тээврийн үйлчилгээг нэг тээврийн хэрэгсэлд 40 зорчигчтойгоор зорчуулж иргэдэд халдвар хамгааллын дэглэм баримтлан үйлчлэхийг зөвшөөрөв,

Гурав.Мал эмнэлгийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Аюушмаа-д:

3.1.Гурванзагал, Чулуунхороот сумдын нутаг дэвсгэрт малын гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан “Хязгаарлалтын дэглэм тогтоох тухай” аймгийн Онцгой комиссын тогтоол гаргах,

Эрүүл мэндийн газрын дарга, Онцгой комиссын гишүүн Ч.Оюунаа-д:


3.2.Гурванзагал, Чулуунхороот сумдын нутаг дэвсгэрт малын гоц халдварт өвчний сэжигтэй тохиолдол илэрсэнтэй холбогдуулан тус сумдын Онцгой комисст зөвлөмж, чиглэл хүргүүлэх,

Дөрөв.Гаалын газрын дарга, Онцгой комиссын гишүүн Б.Гэрэлт-Од-д:

4.1.Хилийн боомтуудын импортоор авдаг эрчим хүч тасалдсантай холбогдуулан дотоодын эрчим хүчээр хангах талаар дээд шатны байгууллагад албан бичиг уламжлах,

Аймгийн Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга, Онцгой комиссын Х.Бат-Эрдэнэ-д:

4.2.Хилийн боомтуудын импортоор авдаг эрчим хүч тасалдсантай холбогдуулан Гадаад харилцааны яаманд албан бичиг уламжлахыг тус тус үүрэг болгов.

ДАРГА  М.БАДАМСҮРЭН

/  / М.Бадамсүрэн  
/  / х/ч Б.Цогтбаяр